

“Көртланд, Науву дахь олон эхнэртэй гэрлэлт” хэсгээс

Gospel Topics Essay (topics.ChurchofJesusChrist.org)

Хожмын үеийн гэгээнтнүүд нэг эрэгтэй, нэг эмэгтэйн хоорондын гэрлэлт нь гэрлэлтийн тухай Их Эзэний хүчинтэй хууль гэдэгт итгэдэг. Библийн цаг үед Их Эзэн зарим хүнд олон эхнэртэй байхыг буюу нэг эрэгтэй хүн олон эмэгтэйтэй гэрлэхийг зарлиглаж байжээ. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм байгуулагдсан эхэн үеийн зарим гишүүн мөн Бурханы бошиглогчдоор дамжуулан өгөгдсөн энэхүү зарлигийг хүлээн авч, дагаж мөрддөг байв.

Иосеф Смит олон эхнэртэй байхыг тушаасан илчлэлт хүлээн авсныхаа дараа олон эхнэр авч, ойр дотны хамтран зүтгэгчдэдээ энэхүү ёсыг танилцуулав. Энэхүү зарчим Иосеф, Сүмийн бусад гишүүний хувьд Сэргээлтийн хамгийн хэцүү хэсгийн нэг байсан юм. . . .

Сүм дэх олон эхнэр авах ёс хэрэгжиж эхэлсэн нь

. . . Иосеф 1834-өөс 1842 оны хооронд нэгэн тэнгэр элч түүн дээр гурван удаа ирж, түүний тээнэгэлзэж байсан олон эхнэр авах ёсыг эхлүүлэхийг зарлигласан хэмээн хамтрагч нартаа хэлсэн. Уг тэнгэр элч гурав дахь буюу сүүлийн удаа үзэгдэхдээ устгалын илдтэй ирсэн бөгөөд Иосефыг уг зарлигт бүрэн дүүрэн дуулгавартай байж, эхлүүлэхгүй байх аваас түүнийг сүйрүүлэх болно хэмээн сүрдүүлжээ. . . .

Иосеф, Эмма хоёр

Олон эхнэртэй байх нь үүнд оролцсон бүгдэд хэцүү байв. Иосеф Смитийн эхнэр Эммагийн хувьд энэ нь түүнийг шаналгасан сорилт болж байв. Эммагийн олон эхнэр авах зарлигт ямар хариу үйлдэл үзүүлсэн тухай цэдэглэсэн зүйл ховор байдаг. Тэрээр өөрөө бичсэн ямар ч тэмдэглэл үлдээгээгүй тул түүний бодлыг мэдэх боломжгүй байлаа. Иосеф, Эмма хоёр бие биеэ гүн гүнзгий хайрлаж, хүндэтгэдэг байсан. Иосеф олон эхнэр авсныхаа дараа тэмдэглэлдээ “мохошгүй, цуцашгүй, гуйвшгүй, өөрчлөгдөшгүй, хайр татам Эмма” хэмээн дүрслэн, “хайрт Эмма”-даа зориулан мэдрэмжээ уудалжээ. Иосефыг өөд болсны дараа Эмма хүзүүндээ зүүж байсан зүүлтдээ түүний хэсэг үсийг хадгалсан байв. . . .

Сорилт ба сүнслэг гэрчлэл

. . . Хэлэн Мар Кимбаллын хэлснээр, Иосеф Смит “энэ зарчмыг дагах нь гэгээнтнүүдийн итгэлийн хувьд хамгийн хүнд сорилт байх болно” гэжээ. . . .

Ийм хүнд сорилтыг хүлээж авах шийдвэрийг ихэвчлэн чин сэтгэлээсээ залбирч, гүн гүнзгий тунгаан бодсоны дараа л гаргадаг. Бригам Янг олон эхнэр авах зарлигийн талаар олж мэдмэгцээ “Би амьдралдаа анх удаа үхэхийг хүсэж билээ. Би зогсолтгүй залбирч, итгэлээ хөгжүүлэх ёстой байлаа. Тэгээд Их Эзэн надад үүний үнэнийг илчлэн, намайг тайтгаруулсан юм” гэж хэлжээ.

Иосеф Смит өөрийг нь эхнэрээ болохыг урихад сэтгэлийн гүн хямралд орсноо Люси Вокэр дурдсан байна. “Миний бодгалийн бүх мэдрэмж үүнийг эсэргүүцэж байлаа” гэж тэр бичсэн байв. Гэсэн ч хэдэн шөнө өвдөг сөгдөн залбирч, нойргүй хоносны эцэст түүний өрөө “нарны цацраг” адил “ариун нөлөөгөөр дүүрэхэд” сэтгэлдээ амар амгаланг олжээ. Тэр “Миний бодгаль урьд хожид мэдэрч байгаагүй сайхан амар амгалангаар дүүрч, бүхэл биеийг минь өгүүлшгүй баяр хөөр эзэлж билээ” гэж хэлсэн.

Дүгнэлт

Олон эхнэр авах зарлиг шиг маргаантай зарчмыг хэрэгжүүлэх сорилт хэцүү байсныг дурдахад илүүц юм. Үүний үнэний талаарх сүнслэг гэрчлэл нь Иосеф Смитэд болон бусад хожмын үеийн гэгээнтэнд энэхүү зарчмыг хүлээн авах боломжийг олгожээ. Хэдий энэ нь хэцүү зарлиг байсан ч Наувуд олон эхнэр авах зарлигийг танилцуулснаар үнэхээр Бурханы “үр удмыг өсгөж” өгсөн. Өнөөгийн үлэмж тооны гишүүд нь олон эхнэр авах зарлигийг хэрэгжүүлсэн итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдийн үр удам билээ.